



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/400

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшиг, осол аваараас урьдчилан сэргийлэх, иргэдийн эд хөрөнгийг хамгаалах зорилгоор Булган сумын төвийн хатуу хучилттай авто зам, гудамж хоорондын зам засварын ажилд 12,000,000 (арван хоёр сая) төгрөг зарцуулах эрхийг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д олгосугай.

2.Авто замын засвар арчлалтад зарцуулах эрх олгогдсон хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д үүрэг болгосугай.

3.Дээрх ажлын хөрөнгийг аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд батлагдсан "Байгалийн гамшгийн үеийн авто зам, замын байгууламжийн засвар" зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

